

*Д.Гэрэлбаатар- ДХИС-ийн Удирдлагын
академийн цагдаагийн удирдлага стратеги
профессорын багийн ахлах багш,
доктор, цагдаагийн хурандаа
Б.Тамир- ДХИС-ийн Удирдлагын
академийн 8032 дугаар дамжааны магистрантн,,
цагдаагийн дэд хурандаа*

ХҮНИЙ ЭРХ БА ГҮЙЦЭТГЭХ АЖИЛ

Товч агуулга: Хүний эрхийн тухай ойлголт, үндэсний эрх зүйн хамгаалалт, гүйцэтгэх ажлын зорилго, эх зүйн зохицуулалтын талаар судаллаа.

Төлхөөрөгс: Хүний эрх, гүйцэтгэх ажил

Оршил: 1990 оноос Монгол Улс нь зах зээлийн эдийн засаг бэхий ардчилсан системд шилжсэнээр хүний эрхийг дээдлэх, хамгаалж, хангах төрийн бодлого хэрэгжиж 1992 онд батлагдсан ардчилсан анхдугаар үндсэн хуульд хүний эрхийн талаар тусгайлан бөлөг болгон тусгасан.

Хүний эрхийг хангаж, хамгаалах нь төрийн ариун зорьго бөгөөд энэ хүрээнд хуулиар эрх олгогдсон тусгай албад гүйцэтгэх ажил эрхэлдэг.

Гүйцэтгэх ажил нь төрийн нууцад хамаарах үйл ажиллагаа тул төдийгүй олон нийтэд нээлттэй бус, энэ утгаараа нийгэмд хардлага дагуулдаг ба улмаар хүний эрхийг зөрчдөг далд нууц үйл ажиллагаа мэт буруу хандлага нийгэмд бий болсоор байна.

Хүний эрх ба Гүйцэтгэх ажил

Хүний эрхийн тухай ойлголт МЭӨ V-VI зууны үед эртний Грект бий болсон “байгалиас заяасан жам ёсны буюу заяагдмал эрх”-ийн сургаалиас эхлэлтэй гэж үздэг.

Орчин үед аливаа улс төрөн хүний эрх, эрх чөлөөг хэр зэрэг хангаж байгаагаар төний олон улсын тавцанд эзлэх байр суурь тодорхойлогддог болжээ. Энэ нь тухайн улс олон улсын эрх зүйн харилцаанд оролцогч бусад субъектүүдээс хамааралгүйгээр оршин тогтнох боломжгүйтэй холбоотой.

Иргэний үндсэн эрх, эрх чөлөөг доктор, профессор Б.Чимид

- > Улс төрийн эрх, эрх чөлөө
- > Нийгэм, соёлын эрх
- > Хувийн халдашгүй эрх, эрх чөлөө
- > Эдийн засгийн эрх
- > Иргэдийн тэгш эрх зэргээр ангилжээ.

Мөн тэрээр иргэний Үндсэн эрхэд байцаан шийтгэх ажиллагааны талаарх эрх буюу процессын эрх гэсэн ангилалт байх нь зүйтэй ба энэ нь Монгол Улсын Үндсэн хуульд тусгалаа олсон хэмээн тэмдэглэсэн байдаг.¹

1992 оны 1 дүгээр сарын 13-ны Өдөр Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Ардын Их Хурлаас ардчилсан анхдугаар Үндсэн хуулийг батлан гаргасан бөгөөд хэний эрх, эрх чөлөөг эрхэмлэн дээдлэхээ тунхагласан. Мөн хэний эрх, эрх чөлөөний тухай Үндсэн хуулийн 2 дугаар бөглөгт заасан.

Иргэдийнхээ эрх, эрх чөлөөг хамгаалах нь төрийн эрхэм зорилго мөн. Монгол Улсын Үндсэн хуулийн 19 дүгээр зүйлд “Төрсөн хэний эрх, эрх чөлөөг хангахуйц нийгэм, эдийн засаг, хууль зүйн баталгааг бүрдүүлэх, хэний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх зорилгыг иргэнийхээ мөн хариуцна” гэж заасан.²

Монгол Улс НҮБ-ийн бүрэн эрхт гишүүний хувиар тухайн байгууллагын дүрэмд заасан хэний эрхийг хангах, хамгаалах төрийн бодлогоо дараах тогтолцооны дагуу Үндэсний байгууллагуудаараа дамжуулан хэрэгжүүлж байна. Үүнд:

1. Хэний эрхийг хамгаалах төрийн механизм
2. Хэний эрхийг хамгаалах орон нутгийн механизм
3. Хэний эрхийг хамгаалах тусгай чиг үүрэг бүхий Үндэсний байгууллага
4. Иргэний нийгэм.

Эдгээрээс хэний эрхийг хамгаалах төрийн механизмд:

1. Хууль тогтоох эрх мэдлийн байгууллага /Улсын Их Хурал/
2. Гүйцэтгэх эрх мэдлийн байгууллага /Засгийн газар, төрийн харьяа байгууллагууд/
3. Шүүх эрх мэдлийн байгууллагууд /Монгол Улсын Үндсэн хуулийн цэц, бүх шатны шүүх, прокурорын байгууллагууд/ хамаарна.

Төрсөн хуулиар баталгаажуулсан иргэний эрх, эрх чөлөөнд халдсан нийгэмд аюултай гэм буруутай үйлдэл, эс үйлдэхгүйг Эрүүгийн хуулиар гэмт хэрэгт тооцож эрх, эрх чөлөөг нь хамгаалдаг. Эрүүгийн болон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу иргэдийн Үндсэн хуулиар баталгаажсан эрхэд халдсан үйлдэл эс үйлдэхгүйтэй тэмцэх зорилгоор гэм буруутай этгээдийн эрхэнд төр халддаг. Энэ нь Үндсэн хуулийн 2 дугаар бөлийн 13 дугаар зүйл “Монгол Улсын иргэн халдашгүй, чөлөөтэй байх эрхтэй. Хуульд заасан Үндэслэл, журмаас гадуур дур мэдэн хэнийг ч нэгжих, баривчлах, хорих, мөрдөн мөшгих, эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно. Хэнд боловч эрүү шүүлт тулгаж, хөндлөг бус, хэрцгий хандаж, нэр төрийг нь доромжилж болохгүй. Баривчилсан шалтгаан, Үндэслэлийг баривчлагдсан хүн, төрийн гэр бүлийнхэн, өмгөөлөгчид нь хуульд заасан хугацаанд мэдэгдэнэ. Иргэний хувийн ба гэр бүл, захидал харилцааны нууц, орон байрны халдашгүй байдлыг хуулиар хамгаална”³ гэж зааснаас үүдэлтэй. Ийнхүү иргэдийн эрх, эрх

¹Б.Чимид “Үндсэн хуулийн мэдлэг” УБ., 2008, 107 дах тал.

²Монгол Улсын Үндсэн Хууль. Төрийн мэдээлэл, УБ., 1992. №1.

³Монгол Улсын Үндсэн Хууль. Төрийн мэдээлэл, УБ., 1992. №1.

чөлөөнд халддаг гэмт явдалтай тэр олон арга хэлбэрээр тэмцдэгийн нэг нь гүйцэтгэх ажил юм.

Аливаа тэр улс өөрийн өндэсний аюулгүй байдал, иргэдийнхээ эрх, эрх чөлөө, тусгаар тогтнолоо хангах, хамгаалах зорилгоор явуулдаг нууц арга ажиллагааг олон улсад тагнуулын ажил, манай улсад Гүйцэтгэх ажлын тухай хуульд заасны дагуу “гүйцэтгэх ажил” гэж нэрлэдэг.

Монгол Улсын Их хурлаас 1997 оны 12 дугаар сарын 19-ний өдөр Гүйцэтгэх ажлын тухай хуулийг батлан гаргасан бөгөөд уг хуулийн 2 дугаар зүйлд “өндсөний аюулгүй байдал, хэний эрх, эрх чөлөөг гэмт халдлагаас хамгаалах зорилгоор төрийн эрх бөхий байгууллагаас ердийн ба тусгай, нууц арга, хэрэгсэл ашиглан явуулж байгаа мэдээ, мэдээлэл, баримт бичиг, нотолгоо эрж олох, цуглуулах, шалгах өйл ажиллагааг гүйцэтгэх ажил гэнэ” гэж тодорхойлон заасан.¹

Мөн хуулийн 4 дүгээр зүйлд ‘Гүйцэтгэх ажилд өндэсний болон нийгэм, төр, иргэний аюулгүй байдлыг хангах, хууль дээдлэх, шударга ёс, тэгш байдал, хэний эрх, эрх чөлөөг хөндөх, шуурхай, тасралтгүй байх, нууц хамгаалах зарчмыг удирдлага болгоно’, 8 дугаар зүйлийн 8.7-д “гүйцэтгэх ажлын явцад хуульд заасан өндөслэл, журмаас гадуур хэний эрх, эрх чөлөөг зөрчих, хууль ёсны ашиг сонирхолд нь халдах, гүйцэтгэх ажлын өр дөнг хууль бусаар ашиглах, гүйцэтгэх ажлын мэдээ, баримт сэлтийг хуурамчаар өйлдэх, хуульд зааснаас бусад тохиолдолд гүйцэтгэх ажлын явцад олсон хувь хэний нууцад хамаарах мэдээллийг задруулахыг хориглоно” гэж заасан.

Дээрхээс дүгнэвэл манай улсад Гүйцэтгэх ажлыг өндэсний аюулгүй байдал, хэний эрх, эрх чөлөөг гэмт халдлагаас хамгаалах зорилгоор өндэсний болон нийгэм, төр, иргэний аюулгүй байдлыг хангах зарчмыг удирдлага болгон эрх бөхий байгууллагуудаас явуулах, хуульд заасан өндөслэл журмаас гадуур явуулахыг хориглохоор хуульчлан тогтоосон байна.

Гүйцэтгэх ажлын тухай хуульд заасны дагуу Тагнуулын ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Авилгатай тэмцэх газар гүйцэтгэх ажил эрхлэн явуулж байна. Эдгээр байгууллагууд тус тусын чиг үүргийн хүрээнд, Гүйцэтгэх ажлын тухай хуульд заасан өндөслэл, хүрээ хязгаарт гүйцэтгэх ажлыг эрхэлж байгаа бөгөөд өйл ажиллагаанд нь Улсын ерөнхий прокурор, төрийн тусгайлан эрх олгосон прокурор хяналт тавьдаг. Мөн УИХ, Засгийн газар шаардлагатай гэж эзэл өөрийн бөтөц дэх зохих нэгж, албан тушаалтнаар дамжуулан гүйцэтгэх ажил эрхлэн явуулж буй байгууллагын өйл ажиллагаанд хяналт тавихыг хуульчилсан.

Сүүлийн жилүүдэд гүйцэтгэх ажил нь ямар нэг хөндлөнгийн хяналтгүйгээр хэний эрхэнд хууль бусаар нууцаар халддаг, хэний эрхийг бодлолгөөр зөрчдөг, эрхдэн шүүлтийн хэрэгсэл мэт, нэр томьёоны хувьд “гүйцэтгэх ажиллагаа” гэх зэргээр хэвлэл мэдээллийн хэрэгсэл, улс төрчдийн

¹Гүйцэтгэх ажлын тухай хууль. Төрийн мэдээлэл, УБ., 1998. №3.

мэдэгдэлдээр олон нийтэд буруу ташаа ойлголт өргөн тархаж байна. Энэ байдалд нийгмийн нийгмийн завхрал, хэт улс төржилт, нийтийн эрх ашгаас дээгүүр хувийн болон хэсэг бүлгийн эрх ашгийг дээгүүрт тавьж буй ашиг сонирхлын зөрчлөлд нөлүүлж байгааг дурьдах нь зүйтэй.

Аль нэг гүйцэтгэх ажил эрхэлж буй байгууллагын алба хаагчийн хууль зөрчсөн үйл ажиллагааг /ялангуяа өөрт олгогдсон эрх мэдлийг хэтрүүлэх, урвуулан ашиглах замаар хууль бусаар иргэдийн эрх, эрх чөлөөнд халдсан, эрүүдэн шүүсэн, албан ёсоор ажилдаа санаатайгаар хувийн ашиг сонирхлын өнднээс хандсан/ өндэслэн гүйцэтгэх ажлыг шүүмжлэх нь зохимжгүй юм.

Орчин цагийн дэлхийн улс төрөн бүр өөрийн улсынхаа өндөсний аюулгүй байдал, иргэдийнхээ эрх, эрх чөлөөг тусгай албадынхаа хүч, туслалцаатайгаар ханган хамгаалж байна. Тэдгээр тусгай албадын үйл ажиллагаа нууц байдаг нь иргэд, олон нийтийн хардлагыг байнга дагуулдаг тул хэнийг, хэзээ, хэрхэн тагнаж байгаа нь нууц, ямар үйл ажиллагаа эрхэлдэг нь олон нийтэд нээлттэй байх жишиг ихэнх улс орнуудад зонхилж байна. Энэ ч өднөөс Монгол Улс 1997 онд Гүйцэтгэх ажлын тухай хуулийг цаг өөийн нөхцөл байдалтай уялдуулан шинэчлэн найруулах, төгсчлөн гүйцэтгэх ажлын процессын хуультай болох асуудлыг ч хийгдэж тавих цаг болсон гэж үзэж байна.

Цагдаагийн байгууллагын хувьд төгсхөн он жилүүдэд хийгдэж ноцтой, жигшүүрт олон гэмт хэргийг гүйцэтгэх ажлаар өндөр хариуцлага, ур чадвар бүхий ажилтнуудынхаа хүчээр илрүүлж байсан арвин туршлагатай. Өөнийгээ ч ард төмөн, иргэддээ сурталчлан таниулж байсны нэгээхэн хэсэг нь “Хүний амь”, “Хуучин сүмийн нууц” зэрэг кино бүтээлүүд билээ.

Цагдаагийн албанаас явуулах гүйцэтгэх ажил нь гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай этгээдийг тогтоохоос гадна гэмт хэргийг урьдчилан сэргийлэх, таслан зогсоох төгсчлөн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсэгт заасан гэм буруугүй хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцохгүй байх, хүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээх зорилтыг хангахад чухал ач холбогдолтой үйл ажиллагааг гэдгийг зориуд онцлон тэмдэглэх нь зүйтэй.

Дүгнэлт

Гүйцэтгэх ажлын тухай хуульд эрх бүхий байгууллагууд хуульд заасан өндөслэл журмын дагуу үйл ажиллагаа явуулахыг зааж, гол зорилго нь өндөсний аюулгүй байдал, хүний эрх, эрх чөлөөг гэмт халдлагаас хамгаалах явдал гэж хуульчилсан. Харамсалтай нь өнөөдөр нийгэмд гүйцэтгэх ажил гэдэг нь бусдыг эрүүдэн шүүдэг, хууль бусаар тагнаж, мөрдөн мөшгидэг, хилсээр хэрэг хийлээлдэг ажиллагаа мэтээр яригдаж, бичигдэж байна. Энэ нь ч гүйцэтгэх ажил эрхэлдэг байгууллагад ажилладаг алба хаагчдаас хүний эрхэнд халдах, улмаар эрүүдэн шүүх зэрэг гэмт хэрэгт холбогдож байгаатай холбоотойгоор нийгэмд хардлага төрүүлж байна.

Цаашид гүйцэтгэх ажил эрхлэн явуулдаг байгууллагад ажиллах алба хаагчдад нэгдэл шалгуур тавих, эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, нэр томъёог нэг мөр ойлгох, иргэд олон нийтэд гүйцэтгэх ажлын зорилго нь иргэдийн эрх, эрх чөлөөг гэмт халдлагаас хамгаалах зорилготой, эрхэдэн шалт болон хууль бус үйл ажиллагаатай огтхон ч холбоогүй гэдгийг сурталчлан таниулах шаардлагатай. Мөн гүйцэтгэх ажил гэх ойлгомжгүй нэр томъёог нэг мөр болгон эрдэмтэн, судлаач, практик байгууллагын ажилтнуудыг оролцуулан процессын хууль боловсруулан хууль тогтоох байгууллагаар батлуулах цаг болжээ.

Эх сурвалжын жагсаалт

1. Монгол Улсын нэгдсэн Хууль. Төрийн мэдээлэл, УБ., 1992. №1
2. Гүйцэтгэх ажлын тухай хууль. Төрийн мэдээлэл, УБ., 1998. №3.
3. Чимид.Б “нэгдсэн хуулийн мэдлэг”, УБ., 2008
4. Одбаатар.Б, Мөнхбаяр.Д “Хүний эрх ба мөрдөн шалгах ажиллагаа”, УБ., 2016
5. Нармандах.Б “Хүний эрх”, УБ., 2010
6. “Хууль сахиулахуйн удирдлага” сэтгүүл, УБ., 2020., №1